



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/300

Булган сум

┌ Булган аймаг дахь Шүүхийн тамгын газарт
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.15 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүүхийн үйл ажиллагааг ард иргэдэд танилцуулах, санал асуулга, судалгаа авах, шүүхэд хандах эрх, эвлэрүүлэн зуучлал, бусад холбогдох хууль тогтоомжийг сурталчлах арга хэмжээнд зориулан Аймгийн Шүүхийн тамгын газарт 19,500,000 (арван есөн сая таван зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх дэмжлэгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

